https://doi.org/10.69561/mjac.v25i48.3634 **Article | Fasc.18**

Хорчин үлгэрт дууны түүхэн хөгжлийн тойм

Жан Инжи

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
ORCID: https://orcid.org/0009-0008-7985-9710
Холбоо барих зохиогч: 2763027124@qq.com

Хураангуй: Хорчин нутагт дунху, ухуань, сяньби, кидан, жүрчэн, монгол, манж, хятад зэрэг үндэстэн ар араасаа оршин суусаар ирсэн бөгөөд төрөл бүрийн соёлын солилцооны дунд Хорчин нутгийн өвөрмөц соёл бүрэлдсэн байдаг. Хөгжлийн явцдаа үлгэрт дуу нь ард түмний нийгмийн амьдрал, сэтгэлгээ, ардын зан заншилтай уялдаж, илэрхийллийн хэлбэр, соёлын утга санааг улам баяжуулсаар байна.

Бидний энэ удаагийн судалгааны зорилго хорчин үлгэрт дууны үүслийг тоймлон тодруулж, түүхэн хөгжлийн үе шатыг тодруулж, аман болон бичгийн сурвалжуудаас олж мэдсэн үлгэрт дууны хувилбаруудыг жишээ болгон шинжлэхийг эрхэм болгов. Тус судалгааг хийхэд судалгааны задлан шинжлэх арга гол суурь болох бөгөөд судлаачдын санаа бодол, эл сэдвийн хүрээний тойм судалгааг нэгтгэн дүгнэх аргаар гүйцэтгэсэн болно.

Түлхүүр үгс: *үе шат, хэв маяг, туульт дуу, уянгат шүлэг, морин эмээлийн дуу*

An overview of historical development of the Khorchin story songs

Zhang Yingzhi

School of Music Arts, Mongolian National Universuty of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
ORCID: https://orcid.org/0009-0008-7985-9710
Corresponding author: 2763027124@qq.com

Abstract: The Khorchin, its unique cultural identity has been formed in the midst of various cultural diversity in which Donghu, Wuhuang, Xianbi, Kidan, Jurchen, Mongolian, Manchu, and Chinese people have been living one after and other. The uligert duu (tales in songs) has been enriched greatly its cultural content and meaning as it's been connected to the social life, the mindset, traditional customs of local people.

The purpose of research study is to outline the origin of the uligert duu, to clarify its historical stages, and to analyze the uligert duu versions found in oral and written

Received: 2024.04.01/ Accepted: 2024.08.07 *© Author (s). 2024*

sources as examples. The analysis method of research study is the main basis for this study, and it is carried out by summarizing the views of researchers and the overview of the subject.

Keywords: *stages, styles, epic songs, poet with melody, horse-saddle song*

Оршил

"Үлгэрт дуу" хэмээх нэршлийг судлаач Сэцэнгоо (1981) анх "Монгол үндэстний үлгэрт дууны тухай" өгүүлэлдээ дурдсанаар судалгааны эргэлтэд орсон байдаг. Энэхүү нэршлийг судлаачид "тууль дуу" гэхээс гадна "уянгын шүлэг" ч хэмээн нэрлэсэн байдаг. Тухайлбал, судлаач Б.Бүрэнбэх (1987) "...тууль дуу нь гадаад зураглал болон дотоод уянгыг нэгтгэж, хүний дүр болон үлгэрийн үйл явдлыг зохицуулан уялдуулж, ахуй амьдралын ба нийгэм түүхийн үнэн бодит чанарыг тусгаж өгдөг..." хэмээсэн бол профессор Мандах (1992) "...үлгэрт дуу нь бүрэн үйл явдалтай, уянгалж хүүрнэхийг уялдуулсан уртхан шиг тууль дуу юм..." гэж үзсэн байдаг. Харин судлаач Наранмандал (1987) "Үлгэрт дуу" нэршил нь үлгэрт дууны хэлбэр бүрэлдэн тогтсоны сүүлээр гарч ирсэн хэмээсэн ба "голдуу Мин, Чингийн үе, орчин үеийн "үлгэрт дуу"-г зааж байдаг" гэжээ.

Үлгэрт дууны үүсэл, түүхэн тойм

XX зууны 80-аад оноос судалгааны эргэлтэд орж хэлбэржин бүрэлдэж, хөгжин бадарсан үлгэрт дууны сурвалжийг тодруулахад эртний тууль, ардын дуу, хүүрнэл шүлэг буюу явган үлгэртэй холбон судлахаас өөр замгүй. Учир нь "...орчин үеийн үлгэрт дууны зарим сэдэв, материал, арга барил, зохиомж найруулга нь эртний тууль, ардын дуутай нягт холбогдохын зэрэгцээ эн тэргүүнд өөрийн үндэстний уран зохиолын уламжлалаас үүсэлтэй... өөрийн үндэстний соёлын уламжлалыг залгамжлан шинэчлээд монгол найрагт нэгэн үеийн томоохон ойлголтыг босгожээ..." (Дашбашвалжид 1984, 5) хэмээдэг. Тэрээр Манж Чингийн ноёрхол унахаас өмнө, хойнох түүхэн хугацааг үлгэрт дууны хөгжил бадралын шижир алтан үе гэж үзсэн байдаг.

Харин судлаач Чармайх (1985) үлгэрт дууны сэдэв агуулгын үзэл санааны хэлбэрийг хорчин нутаг дахь атар хагалбарлах, газар тариалангийн бодит түүхэн ахуйтай холбон тайлбарласан байдаг.

Буянтогтох, Хүрэлшаа, Сөхөө нарын судлаачид "Уран зохиолын товч, хорчины тухай" гуравдугаар өгүүлэмждээ (1993) ойрын үеийн хорчин үлгэрт дуунд хорчин соёлын ховор чухал бүрэлдэхүүн нь хөгжин ирсэн тул үлгэрт дууны судалгааны түүхэн зүй, уран зохиол, урлагийн гоо зүй зэрэг олон шинжилгээний цараанд холбогдох ач холбогдолтой (Буянтогтох, Хүрэлшаа, Сөхөө 1993,7) хэмээсэн байдаг.

Үлгэрт дуу үүсэн тархсан нутгийн тухай судалгааг тоймлон үзвэл, хорчин нутагт төдийгүй, хорчин соёлын нөлөөг шууд хүртсэн зарим аймгууд болох Хүрээ хошуу, Найман хошуу, Зоо уд аймгийн Ар хорчин, Харчин зэрэг хөрш зэргэлдээ хошуудад хорчин ардын дууны хэв намба, онцлог бүрэлджээ хэмээн үзэж болохоор байна. Судлаачид үлгэрт дууны сэдэв агуулгыг ерөнхийд нь нэгдүгээрт, газар шороо хийгээд үндэстний оршин тогтнолын тухай сэдэв агуулга, хоёрдугаарт,

янаг хайрын эрх мэдлийн тухай сэдэв агуулга, гуравдугаарт, харгис дарлал болон хэрцгий үйлийг эсэргүүцсэн сэдэв агуулга гэсэн үзэлд тулгуурлаж, үүсэл хөгжлийн байдал, үлгэрт дууны үүсэх үеийн нөхцөл шалтгааныг авч үзжээ. Мөн үлгэрт дууны хэв намбыг өвөр монголын зүүн орны аж ахуй, амьдрал тэмцлээр сэдэвлэн, үлгэрийн үйл явдал нь хөгжингүй, дотоод сэтгэлгээний дэлгэрэнгүй уянгалал, хэл ярианы онцлог зэрэг нь тууль дууны цэлмүүн уянгалаг хэв намбыг бий болгож, өвөр монголын зүүн орны онцгой хэв намбыг илэрхийлсэн байна гэж үзжээ. (Нуунзаяа 2008, 18) Үүнээс гадна үлгэрт дуу монгол уран зохиол судлалд чухал байр суурийг эзэлж, урлагийн онцлог, агуулгын хуваарилалт, уран зохиол болон соёл шинжилгээний үнэ цэн зэрэг талд шинжлэн судлагдсан байна.

Харин хорчин ардын дууны дүрийн судалгааны хамрах хүрээ нь голчлон дүрс шинжлэл, мотив шинжлэл, хэв загваршил гэх талаасаа олонтоо судлагджээ. Тухайлбал, Сэцэнгоо (1981)-ийн "Үлгэрт дууны уран дүр" судалгаанд үлгэрт дууны дүрийг зөв талын дүр, эсрэг талын дүр гэж задлан шинжлэхдээ, үлгэрт дууны дүрийг түүхэн талаас ба урлагийн талаас нь ялган үзэж, түүний тухайд нийгмийн суурь ба тухайн үед үзүүлсэн ач холбогдлыг үнэлбэл зохино" хэмээн онцолсон байдаг. Судлаач Бо Шиу Лан (1997) хорчин ардын дуун дахь эмэгтэйчүүдийн дүрийг баатар хэв төрлийн дүр, гунигт хэв төрлийн дүр, садар хэв төрлийн дүр гэх байдлаар төрөлжүүлэн шинжилсэн бол Хүрэлшаа, Сэргэлэн нар (1999)-ын судлаачид хорчин монголын ардын домогт дууг тухайн домог, үлгэртэй нь холбогдуулан домог, гоо зүйн талаас системтэй онолын судалгаа хийсэн байна. Тэгвэл хамгийн сүүлийн үеийн судалгаа болох судлаач Хөгжих (2024)-ийн "Монгол ардын аман зохиолын уран дүрийн судлал" бүтээлийн V бүлэгт "Үлгэрт дуу бий болсон нь юуны өмнө нийгэм түүхийн гүн гүнзгий үндэс шалтгаантай байсан бөгөөд ойр орчин үеийн монголын нийгэм, түүхэн байдал үлгэрт дууны үүслийн чухал шалтгаан болно. Үүний дагуу нийт монголчуудын баатрын шүтлэг үлгэрт дууны үүсэл төлөвшил түүний уран дүрт нөлөөлсөн байна. Баатарлаг тууль, хуурын үлгэр, уламжлалт ардын дуу зэрэг бол үлгэрт дууны үүсэл хөгжлийн урлагийн хөрс шороо мөн" хэмээн үзэхийн зэрэгцээ үлгэрт дууны онцлог, сэдэв агуулгын уран дүрд задлалт хийж бослогын баатар, эмэгтэй баатар, лам хуврагын дүр хэмээн хуваарилан үзсэн байна.

Үлгэрт дууны үүсэлд холбогдох түүхэн мэдээ сурвалжийг шинжлэн үзвэл, 1206 онд Их Монгол Улс байгуулагдсаны дараа Чингис хаан нүүдэлчин ард түмний уламжлалт зан заншлын дагуу хүн ам, тал нутаг бэлчээрийн газрыг ойр дотныхоо хүмүүст хуваараж өгсөн түүх бий. "Монголын нууц товчоо"-нд Хавт Хасарт дөрвөн мянган өрх хуваарилсан гэж тэмдэглэсэн байдаг. Түүний нутаг дэвсгэр нь Эргүнэ гол, Хөлөн нуур, Хайлаар голын дагуух өргөн уудам бэлчээр бүхий уул, ойн бүс юм. Үүний талаар судлаач, хуурч Цан Мин "Хорчин товчоон" (2016) бүтээлдээ "Юань улсын үеийн Хасарын ургийн хувь нутаг нь Эргүнэ мөрний сав газар ба түүнээс баруун тийш нутгаар төв болгож, баруун тийш Билгүүдэйн ургийн нутагтай залгаж, зүүн тийш ба өмнө тийш Одчихын ноёны нутаг улстай хөршилж, урагшаа гадаад Байгаль нуураас зүүн өмнө зүг хүртэлх өргөн уудам газар нутгийг багтаажээ" (Цан Мин 2016, 17) гэж дурдсан байдаг. Энэ мэт ихэнх түүхчдийн судалгаанд Юань гүрнээс Мин гүрний дунд үе хүртэлх хугацаанд Хорчин ястан

хүчирхэгжиж, дорно зүгт ноёрхож байсан талаар тэмдэглэжээ. Энэ нь даруй XIII зуунаас XV зууны дунд үе хүртэлх цаг үеийг хэлж байна. Иймээс Хорчин аймаг нь Хөлөнбуйрын тал нутгийн Хайлаар голын сав газраар нүүдэллэн амьдарч байжээ. Газар нутгийн байршлаас шалтгаалан уламжлалт ан агнуурын соёл хорчины хөгжмийн хэв маягт нөлөөлсөн байдалтай ба буриад угсаатантай төстэй байсныг судлаачид тэмдэглэсэн.

Хорчин үлгэрт дууны хөгжлийн хэв маяг, үе шат

Судлаач Улалж "Эртний монголын хөгжим, бүжгийн талаарх урьдчилсан судалгаа" бүтээлдээ хорчин үлгэрт дууг 1. Эртний үе; 2. Тал нутаг мал малжих үе; 3. Орчин үе гэсэн хөгжлийн гурван үе шатыг дамжин хөгжсөн гэх ба түүнийгээ "Гурван өөрчлөлтийн онол" хэмээн томьёолсон байдаг (Улалж 1985, 230).

Монгол ардын үлгэрт дууны эх үүслийг XIII зууны морин цэргийн үетэй холбон үзэж, тухайн үед ихэвчлэн морин дээр дуулагдаж ирсэн уламжлалаас үүдэн "Морин эмээлийн дуу" ч хэмээн нэрлэх талтай. Монгол цэргийн эрэлхэг зоригийн ачаар үлгэрт дуунууд нэн баялаг сэдвийг агуулж, хурдацтай хөгжлийг ахиулсан гэх ба XIII зуунаас хойш үлгэрт дуу тийм ч олон уламжлагдаагүйг судлаач Улалж өөрийн бүтээлдээ онцолсон (Улалж 1998, 77). Тэрээр хорчин үлгэрт дууны түүхэн үечлэлийг эртний хорчин, Нуун[1] хорчин, орчин үеийн хорчин гэсэн гурван үе шатад хуваж үзсэн. Иймээс бид хорчин үлгэрт дууны түүхэн хөгжлийн үе шатыг мөн дээрх үечлэлийн дагуу баримталж, ажиглалт хийхийн зэрэгцээ судалгааны хүрээнд хорчин үлгэрт дуунуудыг эдүгээ амьд сэрүүн үлдсэн цөөн хэдэн өвлөн уламжлагч нараас тодруулан сурвалжлахыг зорьсон ч эртний үед хамаарах үлгэрт дуунуудын ихэнх нь бүрэн байдлаар олдсонгүй.

1. Эртний хорчины үе. Эл үед хамаарах "Ардаг чамбай", "Чингис хааны хоёр загал", "Өнчин хүүгийн домог", "Өнчин нөр[2]" мэтийн дуунууд байна. Тухайлбал, эдгээрээс "Ардаг чамбай" дууны талаарх мэдээллийг судлаач Түн Жан Үн (2010)-ий нэг сэдэвт бүтээлээс олж үзсэн бөгөөд тус үлгэрт дуунд эртний монгол цэргүүдийн дайны амьдралыг дүрсэлсэн, дайчин эрчүүдэд зориулсан эх орноо санагалзсан байдлыг өгүүлдэг. Эртний үед хамаарах хорчин үлгэрт дуу нь богино хэмжээний, цөөн дүртэй, энгийн үйл явдалтай байдгаараа онцлог. Тэгвэл судлаач Түн Жан Үн "Ардаг чамбай" дууг XIII зууны 30-аад оны үед монголын цэрэг Алтан хаант улс руу довтолж байсан үеийг илэрхийлсэн (Түн Жан Үн 2010, 25) хэмээн үздэг. Дууны аялгууг Түн Жан Үний ноотлон тэмдэглэснээр энд хавсаргав (*Зураг 1*).

Хорчин монголчууд эрт дээр үеэс тулааны хийморьтой, зэрлэг байгальд ан хийх дуртай, ан агнуурын томоохон үйл ажиллагаа эрхэлдэг ард түмэн байсныг илтгэх, ан агнуурын агуулга бүхий үлгэрт дууны жишээнд "Өнчин нөр" үлгэрт дууг хэлж болно (*Зураг 2*). Тус дууны үлгэр нь монголчуудын ан хийж байх үед нэгэн буга өөрийн төлөө дагуулан зугтааж, амьд үлдэж гарах гэзэг харамсалтай нь тэрээр хүнд бэртсэн ч төлөө бүслэлтээс гаргана гэж зүтгэсээр ядарсандаа нас барсан тухай өгүүлдэг (Түн Жан Үн 2010, 28).

[1] "Нуун" гэдэг голын нэр. Эл гол одоо Хятадын Нэй лон жан мужийн нутгаар урсдаг.

[2] Хорчингуудын аман ярианд "нөр" гэж бугын төлийг хэлдэг.

Ардаг чамбай



Хүдэр цагаан чулуу нь
Хэдий хүнд боловч
Үеэр голийн усандаа
Эрхэвш үгүй хөдлөнө

Хархан бага үр чинь
Хөдий бага боловч
Хааны цэргийн албандаа
Эрхэвш үгүй мордоно.

Хүний ганцхан үр чинь
Хэдий бага боловч
Эзний цэргийн албандаа
Эрхэвш үгүй мордоно

Хүдэр цагаан чулуу нь
Хөвхөс гэж хөдлөс даа
Эзэн хааны цэргээс
Эргэх зарлиг бууядаа.

Хонин цагаан чулуу нь
Хэдий хүнд боловч
Хайл голийн усандаа
Эрхэвш үгүй хөдлөнө.

Зураг 1. *"Ардаг чамбай" дууг Түн Жан Үний ноотлосноор*

Өнчин нөр



Алтай хангай ар дээр
Арван гурван суга байна
Алаг цоохор нэгэн суга нь
Амраг нөртөйгөө хэвтэж байна

Арван орны эзэн хаанаас
Аавийн зарлиг аа зарлачихлаа
Ангийн ахмад Андай мэргэн
Уулыг дараад алаад ирлээ

Эрдэнэ хангайн өвөр дээр
Ёс арван суга байна
Эрээн цоохор нэг суга нь
Энхрий өргөөтэйгөө зогсож байна

Отрын хүмүүс чинь урдуур явнаа
Уутын хүмүүс чинь хашиж явнаа
Уриа татаад урагшилж явнаа
Утаа тавиад хумиж явнаа

Гүрний эзэн улсын хаанаас
Гүрээлэх зарлиг аа зарлачихлаа
Хүрээний түрүү Андай мэргэн
Хөндийг дараад манайд ирлээ

Гурвалжин хангайд голдож боолоо
Говь тал зүг гудагнаад
Голдож анчин нар дагаж нэхэж
Гульзиитлаа тэлээд нэмээд ирлээ.

Зураг 2. *"Өнчин нөр" үлгэрт дууг Дархан хошууны Бадамын дуулснаар*

2. Нуун хорчины үе. “Нуун хорчин”[3] гэж нэрлэгддэг үе нь Хятадын Мин гүрний үе, Хавт Хасарын 14 дахь үеийн удам Гүйменкетасхар (奎猛克塔斯哈喇) цэргээ удирдан өөрийн нутгаас урагш хөдөлж, Нуун мөрний сав газарт нүүдэллэн суурьшсан үеийг хэлдэг. “XVI зууны 30-аад онд Түмэй заяагч ахмад хөвүн (хүү) Гүйменкетасхар өөрийн харьяат хорчин түмний хэсэг аймаг иргэдийг дагуулан Онон, Эргүнэ нутгаас Хянган даваан өлгийд их даваяны Нуун мөрний сав газарт нүүдэллэн хүрч тэндэх монгол, жүрчэд аймаг угсаатанг эрхшээлдээ оруулснаар харьяат хүн амаар олон, газар нутгаар өргөн уудам (Нуун хорчин) анхлан бүрэлдэж, тэрчлэн Цахар, Өвөр таван халихтай хамтаар тухайн үеийн Мин улсын Лодүнин хязгаараас гаднах хамгийн том сөрөг хүчин болжээ” (Цан Мин 2016, 183). Энэ үеэс “Нуун хорчин” гэж нэрлэх болж, Нуун мөрний сав газарт нүүж, Лиао Хэ[4] голын орчим хүртэл газар нутгийг өргөтгөсөн байна.

Нуун хорчины үеийн хөгжмийн хэв маяг монгол аймгуудын нөлөөгөөр маш их хөгжсөн онцлогтой. Их Хянган уулсыг гэтлэн, одоогийн Сонляогийн тал руу нүүдэллэсэнтэй холбоотой. Холбогдох мэдээллээс үзэхэд, хорчин уртын дууны мөн чанар энэ хугацаанд бүрэлдсэн гэдэг. Харин Юань улсын үеэс өрнөн хөгжсөөр ирсэн үлгэрт ардын дуу нь Мин улсын үед хөгжлийн түвшин буурах хандлагатай болж байжээ. XV зууны дунд үеэс тус дууны хэлбэр нь дахин хөгжиж, нэг бүлэг шилдэг үлгэрт ардын дуунууд сэргэсэн” (Улалж 1998, 175). Иймээс XV зууны дунд үеэс үлгэрт ардын дуунууд бага зэрэг сэргэн хөгжиж, энэ үеийн үлгэрт дуу үгээр урт онцлогтой, домогт шинжтэй болсон байдаг. Тухайлбал, урт үлгэрт ардын дуу “Бисмаа хүүхэн”, “Нуунзаяа” зэрэг домогт шинжтэй үлгэрт дуунууд байна. Мөн “Лүнжин анга”, “Зээдэр наа наа” гэх мэтийн богино үлгэрт ардын дуунууд байна. Жишээлбэл, “Бисмаа хүүхэн” (*Зураг 3*) гэх дууны үлгэрт “Ядуу зүдүү малчин Амгалан, Ван Ца хоёр Бисмаа гэдэг ганц охинтой, Хар мөрний дээд урсгал амар голд нүүдэллэн малжиж байжээ. Бисмаа охин өнгө царайгаар гоёмсог сайхан, цэцэн сэргэлэн, хол ойрынхондоо алдартай сайхан охин байв. Бисмаа эртний монголчуудын цэцэг түүх баярын өдөр бяцхан цагаан луутай уулзаж, түүнтэй хайр сэтгэлтэй болж, улмаар ураглаж, нэг хүүтэй болж, лусын ордонд зол жаргалтай амьдарч байв...” (Улалж 1998, 227) гэж гардаг.

---

3 Хорчин аймгийн анхны газар нутаг бол Хайлаар голын сав газраас Эргүнэ голын сав газар орчим байсан. 200 гаруй жилийн хугацаанд амар амгалан тайван амьдарч байсан. Гэвч Умард Юань гүрний дунд үе гэхэд Монгол хаант улс Оара аймгийн（瓦剌部）хооронд байнга дайн болж байв. Жан Му（张穆）*“Монголын нүүдэлчид”*-д бичсэнээр хятадын Мин гүрний 1425 жилийн орчим, Хавт Хасарын 14 дахь үеийн удам, даруй Хорчин аймгийн удирдагч Гүйменкетасхар（奎猛克塔斯哈喇）дайнаас хол байхын тулд Нуун голоос “зайлсхийж” цэргээ удирдан урагш хөдөлжээ. Их хянган уулсыг гэтлэн одоогийн Сонляогийн тал руу орсон байна. Тэр цагаас хойш Хорчин монголчууд нутгийн Урианхай（兀良哈）монголчуудтай холилдож, тал нутгийн мал аж ахуй эрчимтэй хөгжсөн. Хожим нь өөр нэг бүлэг хорчин монголчууд өмнөд нүүдэллэж, нүүдлийн мал аж ахуй эрхлэх зорилгоор Лууха голын（老哈河）сав газарт нүүж ирсэн. *“Нуу*н хорчин”-*оос ялгахын тулд “*Ар хорчин*”* гэж нэрлэсэн.

4 “Лиао Хэ” бол голын нэр.

Бисмаа хүүхэн



Зураг 3. *"Бисмаа хүүхэн" дууг Тие Ганы дуулж, Улалжын ноотолсноор*

А хаа хөө Бисмаа хүүхэн хөө
Усан өнгөө дагаад урван хөрвөн
Нисээд тээх нь сайхан хөө
Өнгөлөн төрсөн Бисмаа анга хөө
А хаа хөө Бисмаа хүүхэн хөө
Үзэх нүд нь дагаад эвтэй хавтай
Аашлаад тээх нь сайхан хөө
Өргөн жигүүртэй эрээн эрвээхий хөө
А хаа хөө Бисмаа хүүхэн хөө
Өвсний өнгөө дагаад эргэн тойрон
Нисээд тээх нь сайхан хөө

3. Орчин цагийн хорчины үе. "Орчин цагийн хорчин" гэж нэрлэгддэг нь өнгөрсөн 200 гаруй жилийн хорчин нутгийн түүхийн цаг үе болно. Хятадын түүхийн Мин гүрний төгсгөлд Нуун хорчин аймаг хойд Алтан[5] улстай нийлж, одоогийн Тунляо хот руу нүүж, тэдгээрээс залайт, дөрвөд, горлос зэрэг гурван овог аймаг нутаг хошуундаа үлдсэн байна. Тэр үед хорчин, залайт, дөрвөд, горлос гэсэн дөрвөн овог аймаг нэг дээдэстэй байсан тул холбоо байгуулжээ. Чин гүрний[6] эрхшээлд орсноос хойш Чин улсын засгийн газар монголын бүс нутгийг удирдаж захирахын тулд аймаг хошуу системийг баталж, дараа нь "Нуун хорчин" аймгийг манжийн нэгтгэх системийн дагуу Жирим аймаг гэж нэрлээд тэр дөрвөн

[5] Хойд Алтан улс: Чин гүрний өмнөх үе (1616 -1636 он), газрын байршил нь одоогийн хятадын зүүн хойд орон болно.

[6] "Мин улсын сүүлчийн эзэн хаан Чонжэнийн тооллын 9 дүгээр оны (1636 он) 3 дугаар сарын 20-ны өдөр Өвөр монголын 24 хэсгийн 49 феодлын ноёд удирдагч болон Алтан гүрний дараах Монгол болон Хан гүрний 100 гаруй цэргийн дарга Шэньжин хотод хурал хийсэн. Тэд бүгд нийтээр "Богд цэцэн хан"-ыг Алтан эзэнт гүрний дараах хаанаар сонгосон тул мөн тус улсын нэрийг "Их Чин" улс хэмээн өөрчилсөн".

овог аймгийг 10 хошуу[7] болгон хуваажээ (Намсрай 1984, 22). Энэхүү 10 хошууг Жирим аймгийн нутагт байгуулагдсан тул "Жиримийн холбоо" гэж нэрлэж, 1990-ээд он хүртэл үргэлжилсэн байна. Энэ цаг үеэс хойш үлгэрт дуу маш их хөгжих болжээ. Монгол ардын үлгэрт дууны үүсэж бий болсон бас нэг шалтгаан нь байгаль орчны өөрчлөлт юм. 1902 оноос Чин гүрний ноёд Өвөр монголд "Хил рүү нүүх" (移民实边)[8] шинэ бодлого баримталснаас хойш нүүдлийн соёл иргэншил аажмаар газар тариалангийн соёл иргэншилд шилжиж, нүүдэлчдийн амьдралын хэв маяг суурьшлаар солигдох болжээ. Орчин цагийн монголын ард түмний доторх янз бүрийн овог аймгуудын соёлын солилцоо, нэгдэл, харийн үндэстэн ястны соёлын нэвтрэлт зэрэг нь монгол үлгэрт дууны үүсэл хөгжилд түлхэц өгсөн байна. XX зууны эхэн үед зүүн Өвөрмонголд өргөн дэлгэр дуулж байсан монгол үлгэрт ардын дууны ихэнх нь энэ үеийн бүтээлүүд байсан гэж хэлж болно. XIX зууны дунд үеэс хойш үлгэрт дуу дахин шинэ хэв маягаар үүсэн бий болжээ. Орчин цагийн хорчин хөгжмийн хэв маяг нь эртний үлгэрт ардын дууны романтик илэрхийллийн техникийг өөрчилсөн, реализм дээр үндэслэсэн нийгэм, ардын амьдралыг суурь болгож, бодит хүмүүс, бодит үйл явдлыг сэдэв болгосон байдаг. Тиймээс энэ нь орон нутгийн зан заншил, амьдралын уур амьсгалаар дүүрэн байдаг" (Бүтээлт 2015, 74). Хар тамхины дайнаас 1911 оны хувьсгал хүртэлх хагас зуун жилийн хугацаанд бүс нутаг, үндэсний онцлог шинж чанартай олон тооны монгол ардын үлгэрт дуу бий болжээ. Энэ үеийг монгол ардын үлгэрт дууны хөгжлийн алтан үе байсан гэж болно. Орчин цагийн үлгэрт дуу нь үлгэрийн сэдвээр өргөн хүрээтэй байдаг.

Хэлэлцүүлэг

Одоогийн байдлаар 300 гаруй ардын дуу байна. Тухайлбал, баатарлаг сэдэвтэй үлгэрт ардын дуунд "Гадаа мэйрэн", "Бинт Ванны Дуу", "Тогтох", "Өргөлдэй", "Дачин Тал", "Майлас Жанжүн","Шинэ лам", "Намсрай" гэх мэт, харин хайр дурлалын сэдэвтэй үлгэрт дуунуудад "Данабал", "Нулгармаа", "Оюунцэцэг", "Ган рийма","Дүнхэр Да Лам", "Буян хишиг Да Лам" зэрэг дуунуудыг хамааруулан шинжилж болмоор байна. Аж амьдралын сэдэвт үлгэрт дуунд "Алтан сувд", "Алтан цэцэг", "Сэрэнбаосүй", "Линг", "Навчаа гүнж", "Хан шиү ин", "Луяан", "Чүнин" гэх мэт, мөн "Бүргэдчин шувуу", "Тогоруу" зэрэг үлгэрт ардын дуунуудыг хамаатуулан судалж болмоор байна. Орчин цагийн үлгэрт ардын дуунууд агуулга сэдвийн хувьд маш баялаг байдаг. Үүний жишээнд "Нургармаа" дууг (*Зураг 4*) дэлгэрүүлэн авч үзье.

[7] 10 хошуудад: Хорчин зүүн гарын гурван хошуу (Хорчин зүүн гарын өмнөд хошуу, Хорчин зүүн гарын хойд хошуу, Хорчин зүүн гарын дунд хошуу), Хорчин баруун гарын гурван хошуу (Хорчин баруун гарын өмнөд хошуу, Хорчин баруун гарын хойд хошуу, Хорчин баруун гарын дунд хошуу), Горлосын өмнөд хошуу, болон Голросын хойд хошуу, Залайт хошуу, Дөрвөд хошуу зэрэг багтана.

[8] Чин гүрний сүүлч үед дэвшүүлсэн төрийн бодлого. Тухайн үед Найман гүрний холбоотнууд хуучин зуны ордонг шатааж, тэгш бус гэрээ хэлцэлд гарын үсэг зурсан зэргээс болж Чин улсын засгийн газар гадаад, дотоодод асуудалд орж, иймээс Чин улсын засгийн газар монголын газар нутгийг эргүүлэн авах зорилгоор "Хил рүү нүүх" бодлогыг хэрэгжүүлжээ. Зөвхөн 1902-1908 он хүртэл Өвөр монголын их хэмжээний баялаг бэлчээрийг дээрэмдэж, худалдаж, тариалангийн газар болгосон. Монголын олон нүүдэлчид нүцгэн уул, элсэрхэг шүлтлэг газар бэлчээрлэхээс өөр аргагүй болсон.



Агтаа хөлөг морины хаа
Амгайг бас суулгасугай хөө
Ар даа өгсөнсөн саадаг нумаа
Авч бас тайлбуудай хөө

Амраг хонгор Нулгармаа тайгаа
Хэлэлцэж бас завдаагүй хөө
Айл гэрийн аж амьдралаар
Аятай гурав хэлэлцээгүй хөө

Үүрөө хөлөг морь ны хэн
Хөлөөс ны бас сэргээгүй хөө
Үүрсэн зэвсэг саадаг нумаа
Авч бас тайлбуудай хөө

Эвлэг баг Нулгармаа тайгаа тайгаа
Үерхэж бас дасаагүй хөө
Өрөх гэрийн адал амьдралаа
Эстэй гурав зөвдөхгүй хөө

Зураг 4. *"Нулгармаа" дууг Улалжийн ноотолсноор*

Тус дууны үлгэрт "Чин улсын засгийн газраас Тай Пин Таяан Гёогийн хөдөлгөөн (1851-1864)-ийг дарангуйлахын төлөө хорчин нутгаас их хэмжээний цэрэг татав. Нулгармаа болон Алтансүхийн хуримласан тэр өдөр цэрэг татах албанд Алтансүхийг барьсан байна. Алтансүх цэргийн албанд мордсоны сүүлээр айл гэртээ хоцорч суусан эхнэр Нулгармаа хадам ээжийн халыг амсаж, доромжлогдон гутаагдаад эцэстээ төрхөмдөө явжээ. Алтансүх цэргийн албанаасаа буцаж ирсний дараа эхнэр Нулгармаагаа гэртээ буцаан авчирч, хоёулаа жаргаж суусан..." гэж гардаг (Улалж 1998, 363).

1919 оны хөдөлгөөний сүүлээр дундад улс хуучин ардчилсан хувьсгалаас шинэ ардчилсан хувьсгалд шилжин орж, хүмүүсийн үзэл ухамсарт үндэстнээ аврах, хоцронгуй байдлыг устгах сэхээрэл орж эхэлсэн үе юм. Энэ үед хорчин нутгийн монгол сэхээтэн залуучууд ч үндэстэн ястныхаа эрх чөлөөний төлөө тэмцэх шинэ үзэл ухамсартай болж байв. Жишээлбэл, атар хагалбарлахыг эсэргүүцэж газар шороогоо хамгаалах хөдөлгөөн, эмэгтэйчүүдийн эрх чөлөөний төлөө тэмцэл, цэргийн эрх мэдэлтэн, феодал язгууртантай тэмцэх тэмцэл, үндэстнийхээ эрх чөлөөний төлөө зүтгэсэн зэрэг түүхт учир явдал нь үлгэрт дуунд нөлөөлж, энэ тухай тусгасан олон тооны үлгэрт дуунууд орчин цагийн хорчины хөгжмийн хэв маягийг тодорхойлдог. Үүний жишээнд "Намсрай", "Гадаа мэйрэн", "Тогтох", "Өргөлдэй" гэх зэрэг дуунуудыг нэрлэж болох юм.

Дүгнэлт

Хорчин үлгэрт дууны түүхэн хөгжлийг авч үзэхдээ "Үлгэрт дуу" гэсэн нэршилд холбогдох мэдээ баримтаас эхлээд хөгжлийн үе шатуудад ангилан ирсэн байдлыг тоймлон авч үзэхэд дараах байдлаар дүгнэн хэлж болмоор байна.

"Үлгэрт дуу" нэршил нь XX зууны 80-аад оноос эхлэлтэй бөгөөд анх судалгааны эргэлтэд оруулсан судлаач бол Сэцэнгоо (1981) юм. Харин эртнээс уламжлан ирэхдээ "тууль дуу", "уянгат шүлэг", "морин эмээлийн дуу" ч хэмээн нэрлэж ирсэн.

Хорчин үлгэрт дууг хорчин аймаг бүрэлдэх, хөгжих, хувьсан өөрчлөгдөх түүхэн нөхцөл байдлын талаас нь хөгжлийн гурван үе шатад холбон үзсэн байдлыг аман сурвалжийн хүрээнд цуглуулсан хорчин үлгэрт дууны жишээгээр мөшгин тодруулах явцад үлгэрт дууны сэдвийн агуулгын хүрээ арвин баялаг байгаа нь ажиглагдав.

Эрт үеийн үлгэрт дуунууд ихэвчлэн богино хэмжээний, цөөн дүртэй, энгийн үйл явдалтай, уулын, ан агнуурын сэдэв давамгайлж байсан бол Нуун хорчины үед домгийн шинжтэй уртын дуу голчилж байсны зэрэгцээ нэг бүлэгт үлгэрт ардын дуунууд бий болсноороо онцлогтой байв. Орчин цагийн хорчин үлгэрт дуунуудад баатарлаг сэдэв голчилж, нийгэм, аж ахуйн хувиралт, зөрчил тэмцлийн агуулга давамгайлж байгаа нь судалгааны явцаас ажиглагдав.

Ашигласан материалын жагсаалт

Бо Шиу Лан. 1997. "Хорчин ардын дуун дахь эмэгтэйчүүдийн дүрийн хэв төрлийн тухай ажиглалт." *Өвөр монголын багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. Хөх хот.

Бүрэнбэх, Б. 1984. *Уянгын эрэлчийн тэмдэглэл.* Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Бүрэнбэх, Б. 1987. "Монгол шүлгийн гоо зүйн хөгжлийн гол судасны тухай." *Өвөр монголын Багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл* 3. Хөх хот.

Бүтээлт. 2015. *Монголын уламжлалт дуу хөгжмийн тойм онол.* Хөх хот: Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

Дамбишвалжид, П. 1984. "Үлгэрт дууны тухай уран зохиолын шинжилгээ." *Өвөр монголын Багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. Хөх хот.

Мандах. 1992. *Ардын аман зохиолын онол*. Шэньян: Ляонин үндэстэний хэвлэлийн газар.

Намсрай. 1984. *Чин улсын үеийн Монгол хошуу чуулган.* Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн газар.

Тун жан үн. 2010. "Монгол үндэстний Хорчин ястны богино ардын дууны судалгаа." Ph.D дисс., Хятадын төв консерватор.

Улалжи. 1985. *Монголын эртний хөгжим бүжгийн талаарх судалгаа.* Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн газар.

Улалжи. 1998. *Монголын хөгжмийн түүх.* Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн газар.

Хуурч Цан мин. 2016. *Хорчин товчоон.* Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.

Чармайх. 1985. "Үлгэрт дууны хөгжил ба газар шорооны асуудал." *Өвөр монголын Багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. Хөх хот.